

**Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 05.

Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын Нийслэлийг хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн /2021-2025/ төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд тус номын сангаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1.1 Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилсан соёлын олон талт ажил зохион байгуулна.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
1.1.4 Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар номын сангуудын хүртээмж нэмэгдсэн байна.							
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн номын сангийн тоо	Тоо	1	5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НСУГ
9	Номын сангийн фондоод нэмэгдсэн хэвлэмэл ном	Тоо	298,950	353,950	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НСУГ
10	Номын сангийн фондоод нэмэгдсэн цахим ном	Хуудас	7,660	20,000	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	НСУГ

- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн номын сангийн тоо:*

Бүгд найрамдах Солонгос улсын Соёл спорт, аялал жуулчлалын яамны ODA төслийн хүрээнд Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн өргөтгөл 2500 м.кв бүхий шинэ номын санг 2025 оноос барьж эхэлсэн бөгөөд тус номын сан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг хамгийн сүүлийн үеийн байдлаар шийдэж өгсөн.

2025 онд харааны бэрхшээлтэй 566 иргэнд 741 номыг олгож үйлчилсэн ба номын санд ирэх боломжгүй МХҮХ-ны өндөр настай гишүүдийн дунд 18 удаа, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагчдын дунд 2 удаа, нийт 21 удаа чанга уншлага үйлчилгээг зохион байгуулсан. E-pub хүртээмжтэй ном

хэвлэлийг ярьдаг таблет болон бусад апп ашиглан хэрхэн унших тухай 30 удаагийн ганцаарчилсан сургалтыг зохион байгуулсан. Харааны бэрхшээлтэй иргэдэд компьютер, интернэт, ярьдаг таблет, программ хангамж, тусгай хэрэгслийн зөвлөгөө мэдээллийг 140 иргэнд өгч ажиллаж байна.

- *Номын сангийн фондод нэмэгдсэн хэвлэмэл ном:*

Улаанбаатар хотын нийтийн төв номын санд нь 2025 оны тайлант хугацаанд нийт 835 нэрийн 2,360 ширхэг номоор сан хөмрөгийг баяжуулсан. Үүний 793 нэрийн 2,184 ширхэг нь бэлэг, хандиваар, 42 нэрийн 176 ширхэг нь тухайн оны төсөвт тусгагдсан урсгал үйл ажиллагааны зардлаар худалдан авалт хийж тус тус бүрдүүлсэн байна.

Тайлант хугацаанд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар фондын баяжилт хийгдээгүй байна.



1.2 Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж "Хотын соёл"-ыг төлөвшүүлнэ.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь 2025 оны тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд "Хотын соёл"-той холбоотой нийт 62 удаагийн цахим цахим мэдээлэл, богино хэмжээний видео контентыг бэлтгэн цахим орчинд нийтэлж, нийт 217,181 уншигч, хэрэглэгчийн хандалт авсан үр дүнтэй байна. Үүнд:

- "Нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлээрэй" мэдээлэл
- "Хоггүй орчин-Хотын соёл" мэдээлэл
- "Хотын гудмаар явахдаа соёлтой явцгаая" мэдээлэл
- "Хотын соёл хүүхдэдээ цаг баримтлах чадвар хэрхэн заах вэ?"
- "Их хотын соёлыг түгээх 10 зөв дадал"
- "Номын сангаар үйлчлүүлэх соёл"-ын тухай мэдээлэл
- "Замын тэмдгийн ангилал"
- "Хувь хүнээс хамаарах хотын соёл"
- Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)
- Хүүхдийг хайраар хүмүүжүүлбэ
- Хүүхдийн эрх гэж юу вэ?
- Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 5 байршил
- Уншигчийн карт хэрхэн нээлгэх вэ?
- Ном уншихын ач тус
- Брайл бичиг гэж юу вэ?
- Аутизмыг таниулах сар
- Брайл болон цахим номын сангийн үйлчилгээ
- Орой бүр хүүхдэдээ ном уншиж өгөх яагаад чухал вэ?
- Стрессийн тухай ойлголт

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тав тухтай соёлтой зорчих тухай
- "Брайл үсэг сурцгаая"
- "Зөв буруу үйлүүд"
- "Хувь хүний соёл"



- "Зөв хэвшил"
- "Цахим соёл"
- Хуванцар хог хаягдал
- Хотын соёл таниас
- "Хүүхдүүд хогны ертөнцийг өөрчилж чадна"
- "Үйлчилгээний соёл гэж юу вэ?"
- Их хотын иргэн та соёлыг бий болгогч
- Хотын соёл таниас
- Хогоо зх үүсвэр дээр нь ангилж хэвшье
- Хотын соёл-зөв хандлагатай надаас, танаас эхлэнэ.
- Хогоо ангилж сурцгаая видео хийж



- Хотоо цэвэрхэн, аюулгүй, эвтэй найртай байхад та үүнийг дадал болгоорой
- Хотын соёл -оролцоо
- Гоё гудамж-хамтдаа
- Хотын соёл -хувь хүний соёл
- Хотын соёл гэж юу вэ?
- Хоггүй орчин-Хотын соёлын тухай

- Улаанбаатар хот хоггүй, цэвэрхэн болохын болохын төлөө хамтдаа хичээцгээе!
- Зөв хүн байя!
- Цэнхэр алт болсон усаа хайрлая!
- Номын уншиж ойлгох нь



1.3 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр:

Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөрийн үр дүн	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа
Зорилтын үр дүн 2.4. Үндэсний агуулга бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ				
365	2.4.3 Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	4. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн өргөтгөлийг шинэчилнэ	2025-2026

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, спорт аялал жуулчлалын яамны ODA төслийн хүрээнд орчин үеийн стандартад нийцсэн 2,500 м.кв хэмжээтэй "Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн өргөтгөл"-ийн барилгыг бариулах төслийн ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

Уг төслийн хүрээнд өргөтгөлийн барилгын ажил төлөвлөсөн хугацаандаа эхэлсэн бөгөөд барилга угсралтын үндсэн ажил, гадна дулаалга болон гадна зогсоолын ажил бүрэн хийгдэж дуусаад байна.

Өргөтгөлийн барилгын гадна тохижилтын ажил 70 хувь, барилгын гадна пассатны ажил 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа ба гадна цахилгааны шугамын кабель татагдаж, дулаан болон хэрэглээний усны холболтын ажлыг УСУГ, ОСНААУГ гүйцэтгэхээр ажиллаж эхлээд байна.

Барилгын дотор заслын ажлыг гүйцэтгэх тендерийн сонгон шалгаруулалт явагдаж, нийт дөрвөн компани оролцсоноос "NICE THINK SERVICE" ХХК шалгарсан. Тус компани 12 дугаар сараас ажлаа эхлүүлэн ажиллаж байна.

1.4 Нийслэлийн хөгжлийн тухай оны төлөвлөгөөний хэрэгжилт:

201. Соёлын биет бус өвийн мэдээллийн сан үүсгэх, угийн бичиг хөтлөлтийг дэлгэрүүлэх, номын сангийн баяжилтыг хийж, иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх:

Улаанбаатар хотын нийтийн төв номын санд нь тайлант хугацаанд нийт 835 нэрийн 2,360 ширхэг номоор сан хөмрөгийг баяжуулсан. Үүний 793 нэрийн 2,184 ширхэг нь бэлэг, хандиваар, 42 нэрийн 176 ширхэг нь тухайн оны төсөвт тусгагдсан урсгал үйл ажиллагааны зардлаар худалдан авалт хийж тус тус бүрдүүлсэн байна.



Тайлант хугацаанд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар фондын баяжилт хийгдээгүй байна.

202. "Хотын соёл" зорилтот үйл ажиллагааг зохион байгуулах:

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь 2025 оны тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд "Хотын соёл"-той холбоотой нийт 62 удаагийн цахим цахим мэдээлэл, богино хэмжээний видео контентыг бэлтгэн цахим орчинд нийтэлж, нийт 217,181 уншигч, хэрэглэгчийн хандалт авсан үр дүнтэй байна. Үүнд:

- "Нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлээрэй" мэдээлэл
- "Хоггүй орчин-Хотын соёл" мэдээлэл
- "Хотын гудмаар явахдаа соёлтой явцгаая" мэдээлэл
- "Хотын соёл хүүхдэдээ цаг баримтлах чадвар хэрхэн заах вэ?"
- "Их хотын соёлыг түгээх 10 зөв дадал"
- "Номын сангаар үйлчлүүлэх соёл"-ын тухай мэдээлэл
- "Замын тэмдгийн ангилал"

- "Хувь хүнээс хамаарах хотын соёл"
- "Хүүхэд хамгааллын тухай хууль" (шинэчилсэн найруулга)
- "Хүүхдийг хайраар хүмүүжүүлье"
- "Хүүхдийн эрх гэж юу вэ?"
- "Уншигчийн карт хэрхэн нээлгэх вэ?"
- "Ном уншихын ач тус"
- "Брайл бичиг гэж юу вэ?"



- "Брайл болон цахим номын сангийн үйлчилгээ"
- "Орой бүр хүүхдэдээ ном уншиж өгөх яагаад чухал вэ?"
- "Стрессийн тухай ойлголт"
- "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тав тухтай соёлтой зорчих тухай"
- "Брайл үсэг сурцгаая"
- "Зөв буруу үйлүүд"
- "Хувь хүний соёл"
- "Зөв хэвшил"
- "Цахим соёл"
- "Хуванцар хог хаягдал"
- "Хотын соёл таниас"
- "Хүүхдүүд хогны ертөнцийг өөрчилж чадна"
- "Үйлчилгээний соёл гэж юу вэ?"
- "Их хотын иргэн та соёлыг бий болгогч"
- "Хотын соёл таниас"
- "Хогоо эх үүсвэр дээр нь ангилж хэвшье"
- "Хогоо ангилж сурцгаая" видео



- "Хотоо цэвэрхэн, аюулгүй, эвтэй найртай байхад та үүнийг дадал болгоорой"
- "Хотын соёл -оролцоо"
- "Гоё гудамж-хамтдаа"
- "Хотын соёл -хувь хүний соёл "
- "Хоггүй орчин-Хотын соёлын тухай"

- "Улаанбаатар хот хоггүй, цэвэрхэн болохын болохын төлөө хамтдаа хичээцгээе!"
- "Зөв хүн байя!"
- "Цэнхэр алт болсон усаа хайрлая!"
- "Номыг уншиж ойлгох нь"



Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг

Жил бүр улс даяар Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдлэх, сурталчлан түгээх, өвлүүлэн үлдээх, алдаагүй зөв найруулан бичих, монгол хэлний ариун баялаг үгсийн сангаас суралцах, хэл соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилготой Үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгуулдаг уламжлалтай.

Энэ жил тус номын сангаас Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

Уулзалт, зочны ярилцлага:

- "Болор цом"-ын эзэн, яруу найрагч, шог зураач М.Амархүүтэй "Зохиолч-Уншигчдын уулзалт"
- Монгол хэл, бичиг судлаач Д.Цэцэгдэлгэртэй хамтран сурагчдад "Уран бичлэг ба түүхийн жимээр" сэдэвт уулзалт



- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвд судлалын салбарын эрхлэгч ЭШТА, доктор профессор Д.Наранцэцэгтэй зочны ярилцлага
- Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн Монгол уран бичлэгийн багш Гомбын Болормааг урьж зочны ярилцлага



Сургалт:

Үндэсний бичиг үсгийн багш Д.Удвалцэцэгтэй хамтран тулгуур эрхтэний бэрхшээлтэй бүлгэмийн "Түгээмэл хөгжил" ТББ-ын 23 ажилтанд Уран бичлэгийн болон Монгол бичгийн танилцуулга сургалт зохион байгууллаа



Ном зүй:


"Монголчуудын үсэг бичгийн гарал үүсэл, сурах бичиг" сэдэвт ном зүйн жагсаалт бэлтгэн гаргасан.



Номын үзэсгэлэн, цахим мэдээлэл:

"Үндэсний бичиг үсгийн баяр-2025" сэдэвт уйгаржин монгол бичгээр бүтээгдсэн ном товхимолоор үзэсгэлэн гаргаж, "Монгол уран бичлэгийн түүх", "Монгол уран бичлэгийн тухай" видео мэдээлэл, "Монгол эвхмэл бичиг" сэдэвт зурагт мэдээлэл бэлтгэн цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчиллаа.





2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг номын баяр арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор "Илүү их уншъя" уриатай зохион байгуулагдаж манай номын сангаас дараах зохиолч, уншигчдын уулзалтыг зохион явуулсан. Үүнд:

- МЗЭ-ийн шагналт, яруу найрагч, Намбарын Пүрэв "Номын ертөнц ном уншихын ач холбогдол" сэдвээр "Уншигч-Зохиолчдын уулзалт"
- Монголын хүүхдийн уран бүтээлчдийн "Эвт үзэг" төвийн захирал Б.Ганчимэгтэй "Зохиолч-Уншигчдын уулзалт"
- Дэлхийн номын өдөрт зориулан Английн алдарт зохиолч Уиллиам Шекспирийн товч намтар цахим мэдээлэл
- "Динза, Цондоолойгийн анд найзууд" төрийн бус байгууллагын тэргүүн, Хүүхдийн зохиолч Анбатын Дэлгэржаргалтай зохиолч, уншигчдын уулзалт





Номын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Хүртээмжит номын фондыг баяжуулах үүднээс, 116-р сургуулийн сурагчдын дунд явуулсан "Чанга уншлага"-ын өгүүллэгүүдийг эмхэтгэн ярьдаг ном болгон уншлага үйлчилгээндээ нэвтрүүлэн ажилласан.



2.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг

Тус зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Ногоон хот – Иргэний оролцоо" хавар, намарын мод тарих аяны хүрээнд 2022 онд батлагдсан хуваарийн дагуу байгууллага хамт олноороо Хан Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Айдсын аманд 60 ширхэг модны суулгац тарьж, усалгаа арчилгаа хийсэн. Мөн энэ онд аяны хүрээнд заавар зөвлөмжийн дагуу ХУД-ийн 14 хороо айцийн амны заасан байршилд мод тарих үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 60 модыг арчлан, цэнэг усалгаа, нөхөн сэргээлт хийж хог хаягдлыг цэвэрлэсэн.
- 60 модноос 10 мод нь сэргээх боломжгүй байсан тул шинээр 20 ширхэг монос, хар мод худалдан авч суулгалт хийж усалгаа тордолгоо тус тус хийсэн.





Мөн Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод тарих ашиг тусын тухай <https://www.facebook.com/ChingilteiPublicLibrary> пейж хуудсаар дамжуулан Тэрбум мод байгалиа бүтээе, Хүн бүр байгаль хамгаалагч, тэрбум мод байгалиа бүтээе, Хүүхэд бүр байгаль хамгаалагч, Тэрбум мод байгалиа бүтээе!, Мод тарихын ашиг тус, Цөлжилтийн эсрэг хамтдаа, Мод тарья, Алтан намар, Мод тарих цаг зэрэг 4 мэдээлэл бэлтгэн хүргэсэн.



2.4 Монгол улсын засгийн газрын 2022 оны "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 7 дугаар тогтоол

Тус номын сангийн Хан-уул дүүрэг дэх салбар номын сангаас санаачлан Монгол улсын засгийн газрын 2022 оны "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 7 дугаар тогтоолын хүрээнд анхан шатнаас эхэлж сурах хүсэлтэй 26 албан хаагчдад 6 удаагийн 10-20 минутын видео хичээлийг хууль журам, стандартад нийцүүлэн "Хэл бичгийн үндэсний зөвлөл"-с бэлтгэн гаргасан "Төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага"-ыг удиртгал болгон ашиглаж монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг амжилттай хэрэгжүүллээ.



2.5 Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны 03 тоот албан даалгавар

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь санхүү, аж ахуйн үйл ажиллагаандаа төсвийн болон холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөн ажиллаж байна. Байгууллагын зүгээс тавих хяналт шаардлагыг өндөржүүлснээр төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах талаар захиргааны гишүүд, улмаар нийт ажиллагсдын сэтгэл зүйг нэг зүгт хандуулж ажиллаа. Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны 03 тоот албан даалгавар, НЗТГ-ын 2025 оны 08 дугаар сарын 06 -ны өдрийн 03/4947 тоот албан бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заагдсан зарим мөнгөн урамшуулал олгохыг түр хугацаагаар түдгэлзүүлсэн.
- Тэтгэвэрт гарсан болон бусад шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтны оронд нөхөн томилгоо хийлгүйгээр ажилтны ажил үүргийн хуваарийн оновчтой тогтоож, ажлын ачааллыг нягтруулан ажиллаж байна. Одоогийн байдлаар тэтгэвэрт гарсан 1 үйлчлэгч, хүүхэд асаргааны чөлөөтэй байгаа 2 номын санчын оронд шинээр хүн томилохгүйгээр ажлын ачааллыг зохицуулан ажиллаж байна.
- Төв, салбар номын сангийн цахилгааны болон цэвэр бохир усны тоолуурыг тусгай дэвтэрт өдөр бүр тэмдэглэн тухай бүр хяналт тавин, хэрэглээг хязгаарлан ажиллаж байна.
- Бичиг хэргийн материал, цэвэрлэгээний материалуудын өдөр тутмын албан хэрэглээнд хяналт тавин тодорхой хэмнэлт гарган ажиллаа
- Номын сангийн хэмжээнд сургалт, семинар, хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан, аялал зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2.6 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Тус номын сан нь 2025 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулах шаардлагатай бүх мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж, тэдгээрийн үнэн зөв, бүрэн байдлыг ханган, холбогдох хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлэн ажилласан байна. Мөн "Мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах 68 төрлийн мэдээлэл"-ийн shilen.gov.mn систем дэх 1- 4 дүгээр улирлын тайланг бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлж, хугацаанд нь илгээж ажиллалаа.



Төв болон салбар номын сангийн үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1488 жиргээ илгээгдэж, 413 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 53548, үүнээс гадна АСМТ 530311 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг өдөр бүр тогтмол түгээн ажиллаж байна.



2.7. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/1049 дүгээр захирамж

Тус захирамжийн хүрээнд тайлант хугацаанд албан хаагчдаас ирсэн 16 өргөдөлыг байгууллагын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн цахим системийн өргөдөл цэсэнд бүртгэн хуулийн дагуу шийдвэрлэн 100 хувь барагдуулж ажилласан.



Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангууд нь дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Уншлага, үйлчилгээ:

Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаарх уншлага, үйлчилгээний гүйцэтгэлийг “Хүснэгт 1”-д үзүүлэв.

Хүснэгт 1

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Шинэ уншигч	15,800	15,055	95,3%
2	Ирэгсэд	102,500	95,498	93,2%
3	Ном олголт	260,500	198,300	76,1%
Нийт үнэлгээгээр				88,2%

- Номын сан хоорондын солилцоо болон зөөврийн үйлчилгээ:

Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангийн хэмжээнд 2025 онд номын сангийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа байгууллагын албан хаагчид, анги хамт олныг зөөврийн номын сангийн үйлчилгээнд хамруулахаар нийт 115 удаагийн зөөвөр хийхээр төлөвлөснөөс 104 удаагийн зөөврийг 4,782 ширхэг номоор хийж гүйцэтгэлээ.

Мөн номын сан хоорондын солилцоог 20 удаа хийхээр төлөвлөснөөс нийт 22 удаа 426 ширхэг номоор хийж хэрэгжүүлсэн байна.

Зөөвөр:

- 6-р сургуулийн А.Амартуяа багштай 46 ангийн 45 сурагчдад 45 ширхэг номоор
- 46-р цэцэрлэгийн ахлах, бүлгийн хүүхдүүдэд
- 67-р сургуулийн Ө.Өрнөхцэцэг багштай 3а ангийн 41 сурагчдад 41 ширхэг номоор
- 72-р цэцэрлэгийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд
- 111-р цэцэрлэгийн багш, ажилчдад 34 ширхэг номоор
- 303-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд
- 333-р цэцэрлэгийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд
- Нийслэлийн Эрчим цэцэрлэгийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд
- 42-р сургуулийн сургуулийн багш, ажилчдад 35 ширхэг номоор
- Идэр их сургуульд 3 удаагийн 86 ширхэг номоор
- Нийслэлийн 66-р цэцэрлэгт 2 удаагийн 63 ширхэг номоор
- Номт эрдэм өдөр өнжүүлэх төвд 20 ширхэг номоор
- И-Монгол академитай 30 ширхэг номоор
- Хан Ховд сүрвэй ХХК-тай 1 удаа 20 ширхэг номоор
- Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны Энх Амгалан Өлзийт өрхийн эмнэлэг 15 ширхэг номоор
- Хавдар Судлалын Үндэсний Төвийн үйлчлүүлэгчийг дэмжих албатай 20 ширхэг номоор
- Сэтгэмж сургуулийн Ц.Эрдэнэтуяа багштай 36 ангийн 36 сурагчдад 36 ширхэг номоор
- Хан-Уул дүүрэг дэх Хаан банкны Белмонте тооцооны төвийн ажилтнуудад 20 ширхэг номоор
- Баянзүрх дүүргийн 146 сургуулийн Даваадулам багштай 4ж ангид 27ш номоор,
- 48 дугаар сургуулийн Оюун багштай 4з ангид 43ш номоор,
- 127 дугаар сургуулийн номын санч Б.Болормаа 15ш номоор
- 79 дүгээр сургуулийн Б.Золжаргал багштай 5б ангид 35ш номоор,
- 127 дугаар сургуулийн Б.Ариунтуяа багштай 3е ангид 34ш номоор



- Налайх дүүргийн зэвсэгт хүчний 353-р ангийн номын санч М.Сонинцэцэгтэй 94ш номоор,
- Нийслэлийн ерөнхий боловсролын Ерөнц сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Ц.Цэнгэлтэй 30ш номоор
- Дотоодын цэргийн 805 дугаар ангийн хугацаат цэргийн албан байгаа цэргүүдэд 3 удаа,
- НЕБ-ын 16 дугаар сургуулийн Баярсүрэн багштай 3ж ангид 2 удаа ,
- Дотоодын цэргийн ерөнхий боловсролын 49-р сургуулийн номын санд
- Best massage-2 Төвийн харааны бэрхшээлтэй ажилчдад зөөврийн номын сангаар 2 удаа.
- МХҮХ-ны гишүүдэд зөөврийн номын сангаар 10 удаа.
- Best massge-6 Төвийн харааны бэрхшээлтэй ажилчдад зөөврийн номын сангаар 1 удаа.
- ЕБС 116-р сургуулийн сурагчдад зөөврийн номын сангаар 2 удаа
- Хан-Уул дүүргийн 41 дүгээр цэцэрлэгийн Д.Наранцэцэг, Б.Одончимэг багш нартай хамтран 44 ш номоор
- 46-р цэцэрлэгийн М.Хандмаа, О.Ганцэцэг багш нартай хамтран 21 ш номоор
- Ерөнхий боловсролын "Шинэ өргөө сургууль"-тай 25 ш номоор,
- Хан-Уул дүүрэг 2-дугаар хороо 1 удаа 25 ш номоор,



- Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалтай хамтран 17 ш номоор,
- НЕБ-ын114-р сургуулийн 76 ангитай хамтран 43 ш номоор
- Нийслэлийн ерөнхий боловсролын 35 дугаар сургуулийн номын сантай 5 удаа 190 ширхэг номоор
- СУИС-ийн Хүний хөгжлийн төвтэй 1 удаа 41 ширхэг номоор
- Нийслэлийн ерөнхий боловсролын 35 дугаар сургуулийн номын сантай 1 удаа 82 ширхэг номоор
- Нийслэлийн ерөнхий боловсролын 119 дүгээр сургуулийн номын сантай 1 удаа 42 ширхэг номоор
- Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн номын сантай 1 удаа 50 ширхэг номоор
- Шинэ иргэншлийн МСҮТ-д 2 удаа 65 ширхэг номоор
- ЧД-ийн 57-р сургуульд 2 удаа 48 ширхэг номоор
- Зэвсэгт хүчний 017-р ангид 2 удаа 50 нэрийн 50 ширхэг номоор
- НЕБ-ийн 152-р сургуульд 2 удаа 30 нэрийн 30 ширхэг номоор
- Сонгинохайрхан дүүргийн алслагдсан 24 хорооны нутаг дэвсгэрт орших Бумбатын рашаанд ирж буюу хүүхэд багачуудад 1 удаа 25 нэрийн номоор

- НЕБ ын 19 дүгээр сургуультай 2 удаа, 22 ширхэг номоор
- ОУЭЗБДС-ийн харьяа ЕБ-ын ахлах сургуультай 1 удаа, 15 ширхэг номоор
- НЕБ-ын 151 дүгээр сургуультай 33 ширхэг номоор
- Олон улсын эдийн засаг бизнесийн их сургууль 3 удаа 82 номоор
- НЕБ-ын 19-р сургууль 1 удаа 27 номоор зөөврийн үйлчилгээ үйлчилсэн байна.
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролын номын сантай 2 удаа 60 ширхэг боть номоор зөөврийн үйлчилгээ

Солилцоо:

- Шинэ иргэншлийн дээд сургууль 40 ширхэг боть номоор,
- Боловсролын яамны номын санд 40 ширхэг боть номоор,
- Орос 3-р сургуульд 40 ширхэг боть номоор,
- Чингэлтэй дүүргийн 57-р сургуулийн номын сантай 60 ширхэг боть номоор,
- Нийслэлийн 102-р сургуулийн номын сантай ном солилцоо,
- 33-р сургуулийн номын сантай ном солилцоо,
- Глобаль удирдагч дээд сургуулийн номын сантай ном солилцоо,
- Төв номын сангийн "Б" танхимаар
- ЕБС 116-р сургуулийн номын сантай ном солилцоо 2 удаа



- Мандах их сургуулийн номын сантай 2 удаа 20 номоор ном солилцоо
- Нийслэлийн Ерөнхий боловсролын 47-р сургуулийн номын санч Д.Болормаатай 50 ширхэг номоор ном солилцоо
- Хүүхэд залуучуудын театрын дэргэд дэх номын сангаас 1 удаа 4 нэрийн 4 ширхэг номоор солилцоо



- ХУД дэх салбар номын сангийн нийтийн уншлагын танхимтай 2 удаа 30 ширхэг номоор солилцоо
- Салбар номын сангийн НУТ-ын заалтай 20 ширхэг номоор солилцоо
- Олон улсын эдийн засаг бизнесийн их сургууль 9 номоор солилцоо
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсрол 11ш номоор ном солилцоо

- **Мэдээллийн нөөц бүрдүүлэлт болон лавлагаа ном зүйн үйлчилгээ:**

Лавлагаа:

2025 оны тайлангийн хугацаанд Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангууд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааг цахим болон утсаар, амаар нийт 2,881 удаа, бичгээр 3 удаа тус тус өгсөн байна. Үүнд:

➤ Төв номын сан:



➤ Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан:



➤ Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан:



➤ Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан:



➤ Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан:



Ном бүрдүүлэлт:

Улаанбаатар хотын нийтийн төв номын санд нь тайлант хугацаанд нийт 835 нэрийн 2,360 ширхэг номоор сан хөмрөгийг баяжуулсан бөгөөд үүний 793 нэрийн 2,184 ширхэг нь бэлэг, хандиваар, 42 нэрийн 176 ширхэг нь тухайн оны төсөвт тусгагдсан дүнгээр худалдан авалт хийж тус тус бүрдүүлсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтаар ном худалдан авч фондын баяжилт хийгдээгүй байна.

Мөн 17 нэр төрлийн тогтмол хэвлэлийн захиалгыг төв болон салбар номын сангийн хэмжээнд чанартай зохион байгуулж, дугаар ирэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажилласан байна.



Ном зүй:

Ном зүйн үйл ажиллагааг цахим болон хэвлэмэл хэлбэрээр зохион байгуулж, тайлант хугацаанд нийт 38 төрлийн ном зүйн жагсаалт (лист) боловсруулан уншигч, хэрэглэгчдэд хүргэлээ. Үүнд номын сангийн цахим хуудсаар дамжуулан номын мэдээлэл, танилцуулгыг цахим хэлбэрээр тогтмол бэлтгэн нийтэлж, уншлагын танхимд шинээр ирсэн ном, инээдмийн өдөр, Театрын өдөр, Олон улсын дуурийн өдөр, хүүхдийн зохиолчдын цуврал бүтээл, мөн монгол бичгээр хэвлэгдсэн номын танилцуулгыг видео хэлбэрээр хүргэсэн байна. Үүнд

- “Зочны ярилцлага–2019–2023” 18 нэрийн ном,
- “Математикийн элсэлтийн шалгалтад бэлэн үү?” – 40 нэрийн ном,
- МУСГЗ, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Д.Цэнджавын зохиол бүтээлүүд – 21 нэрийн ном,
- Домог, үлгэрийн сэдэвт – 81 нэрийн ном,

